



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН  
РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 1/36

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

МУБИС-ийн тэнхимийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх, салбартаа хүлээн зөвшөөрөгдөхүйц судалгаа, судалгааны баг бий болгох зорилгоор МУБИС-ийн дүрмийн 4.4.1 заалт, Ректорын зөвлөлийн хурлын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Тэнхимийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэл, судалгааг дэмжих хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан хөтөлбөрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг бүрэлдэхүүний болон салбар сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг журмын дагуу шийдвэрлэж өгөхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга (Д.Тогтохбаяр)-д, Санхүү, хөрөнгө оруулалт, аж ахуйн хэлтсийн дарга (М.Уранжаргал)-д тус тус зөвшөөрсүгэй.

4. Тус хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, инновацын газрын дарга (Б.Хоролдагва)-д даалгасугай.

РЕКТОР



Ж.БАТБААТАР

2024-234



**Тэнхимийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэл, судалгааг  
дэмжих хөтөлбөр /2024-2025/**

**Нэг. Зорилго**

Багш нарын хамтын үйл ажиллагаа, тэнхимийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх, салбартаа хүлээн зөвшөөрөгдөхүйц судалгаа, судалгааны баг бий болгох, тэдгээрийн шинжлэх ухаан, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, манлайллыг дэмжихэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

**Хоёр. Хамрах хүрээ, санхүүжилт**

- 2.1. МУБИС-ийн мэргэжлийн тэнхимийн үндсэн багш нарыг хамарсан байх;
- 2.2. Багш нарын хамтын /багийн/ судалгааг дэмжих, хөгжүүлэхэд чиглэсэн байх;
- 2.3. Санхүүжилтийн хэмжээ багш тус бүрд 1 сая төгрөг хүртэл байна.
- 2.4. Хөтөлбөр хэрэгжиж эхлэхэд санхүүжилтийн 70%-ийг, хэрэгжилтийн явцыг үнэлснээр үлдэгдэл 30%-ийг олгоно.

**Гурав. Хугацаа, үйл ажиллагааны чиглэл**

- 3.1. Хөтөлбөрийг 2024 оны 2 дугаар сарын 5-аас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэл хэрэгжүүлнэ.
- 3.2. Тус хөтөлбөрөөр дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ.
  - Тэнхимийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх, судалгааны семинарыг тогтмолжуулах, суралцагчдыг хамруулах;
  - Эрдэм шинжилгээний өгүүлэл (Web of Science, Scopus-д бүртгэлтэй сэтгүүлд), нэг сэдэвт хамтын бүтээл хэвлүүлэх;
  - Гадаад, дотоодын их, дээд сургууль, судалгааны байгууллагын нэгж, судлаачтай хамтран ажиллах;
  - Инновацийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, эзэмших, эдийн засгийн эргэлтэд оруулах;

**Дөрөв. Санхүүжилтийн хяналт, тайлагнал**

- 4.1. Тэнхимийн эрхлэгч хөтөлбөрийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж, бүрэлдэхүүний болон салбар сургуулийн захирлын зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулна.
- 4.2. Хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнахад дор дурдсан шалгуурыг баримтална. Үүнд:
  - Санхүүжилт нь хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг дэмжсэн эсэх;
  - Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн эсэх;
- 4.3. Санхүүжилтийн зарцуулалт, тооцоо, тайлагналыг тэнхимийн эрхлэгч хариуцна.

4.4. Тэнхимийн эрхлэгч хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг бүрэлдэхүүний болон салбар сургуулийн захирлын зөвлөлд тайлагнаж, үр дүнг тооцно.

4.5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг бүрэлдэхүүний болон салбар сургуулийн захирал 2024 оны 12 дугаар сард ректорын зөвлөлд танилцуулна.

